

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

# ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Улаанбаатар хот  
2018 он



## ЭРҮҮЛ МЭНД

2017 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 62 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын 367 их эмч нар иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж ажиллажээ.

Хүснэгт 1. Дүүргийн эрүүл мэндийн салбарын үзүүлэлт, 2008-2017 он

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Эрүүл мэндийн байгууллага	4	4	7	7	7	7	7	5	5	5
Эрүүл мэндийн нэгдэл	1	1	1	1	1	1	1	1	1	1
Өрхийн эмнэлэг	12	13	13	13	14	14	14	15	15	15
Эмнэлэгийн орны тоо	318	224	846	846	846	856	968	968	974	974
Их эмчийн тоо	137	127	211	211	186	192	344	352	367	367
Хувийн эмнэлэг	14	14	29	29	25	27	33	39	41	41
Эмийн сан	46	44	39	39	39	39	58	61	60	81

2017 оны байдлаар эмнэлэгт үзүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 781503 болж, өмнөх оноос үзлэгийн тоо 3062 буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

Он	Эмнэлэгийн үзлэгийн тоо	Төрөлт	Төрөхийн улмаас эндсэн эх	Амьд төрсөн нярай	Нас баралт	Үүнээс: 0-1 нас
2008	610506	2318	0	2346	605	41
2009	591809	2515	0	2533	538	29
2010	647013	2617	2	2631	608	33
2011	693969	2991	1	2995	642	22
2012	731511	3377	3	3407	649	37
2013	779552	3712	5	3737	602	48
2014	779424	4044	3	4091	704	45
2015	789734	4487	1	4510	610	41
2016	778441	4586	2	4613	693	44
2017	781503	4369	1	4400	665	44

Зураг 1. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Дүүргийн хэмжээнд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2017 оны байдлаар 44, эхийн эндэгдэл 1 гарчээ. Төрөлт 2017 оны байдлаар 4369 болж, өмнөх оноос 217 (4.7%) төрөлтөөр буурсан байна. Амьд төрсөн нярайн тоо 2017 онд 4400 байгаа нь өмнөх оноос 213 (4.6%) хүүхдээр буурсан байна.

2017 онд халдварт өвчнөөр өвчилсөн 2386 тохиолдол бүртгэгдсэн нь 2016 оноос 961 (28.7%) тохиолдлоор, 2015 оноос 737 (23.6%) тохиолдлоор тус тус буурсан байна.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн халдварт өвчний гаралт, өвчний төрлөөр

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Халдварт өвчин	1330	1024	985	1467	2155	1265	1200	3123	3347	2386
Үүнээс:										
Вируст гепатит	302	190	138	515	289	93	64	35	27	29
Улаан бурхан	-	-	-	-	-	-	-	1643	1366	1
Гахайн хавдар	39	92	13	70	715	142	19	17	25	14
Менингит	4	2	-	1	-	1	2	-	1	-
Сүрьеэ	223	226	246	200	202	216	231	267	267	253
Заг хүйтэн	97	60	41	67	37	33	21	50	48	35
Цусан суулга	165	216	218	143	177	149	172	208	258	375
Тэмбүү	140	79	91	170	136	136	219	196	120	118
<u>Бусад</u>	356	159	238	301	599	495	472	707	1235	1561

2017 оны халдварт өвчнөөр өвчлөгчдийн бууралтад улаан бурхан өвчнөөр өвчлөгчдийн тоо 1365 тохиолдлоор буурч, нийт халдварт өвчнөөр өвчлөгчдийн 0.04 хувийг эзэлж байгаа нь голлон нөлөөлжээ. Харин 2017 онд вируст гепатит өвчнөөр өвчилсөн тохиолдлын тоо 29

байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2 (7.4%) тохиолдол, 2015 онтой харьцуулахад 6 (17.1%) тохиолдлоор тус тус буурсан байна.

Зураг 2. Халдварт өвчин, вирус хепатит, 2008-2017 он



Танилцуулга бэлтгэсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунгэрэл